



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/76/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Төлбөрийн акт.....	16
4.2 Албан шаардлага	17
4.2 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/106

ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.ЗОРИГТ ТАНАА

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

005020494

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82,657,729.00	118,077,723.00
33	АВЛАГА	1,000,000.00	8,127,200.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,000,000.00	00.00
33200	Төлбөргэй үйлчилгээний авлага	00.00	7,127,200.00
335	Бусад авлага	00.00	1,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	1,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	81,657,729.00	109,950,523.00
351	Түүхий эд материал	40,211,769.00	50,209,279.00
35110	Тусгай зориулалттай материал	40,211,769.00	50,209,279.00
354	Хангамжийн материал	32,145,960.00	58,791,244.00
35410	Бичиг хэргийн материал	2,127,375.00	2,935,875.00
35420	Аж ахуйн материал	4,273,750.00	21,013,534.00
35450	Барилгын засварын материал	596,580.00	596,580.00
35470	Бусад хангамжийн материал	25,148,255.00	34,245,255.00
35600	Мал амьтад	9,300,000.00	950,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,912,672,520.81	1,856,714,605.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,912,672,520.81	1,856,714,605.61
392	Биет хөрөнгө	1,814,504,520.81	1,767,286,605.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,915,954,298.11	1,948,021,942.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-429,214,836.55	-479,622,104.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	167,851,800.00	166,101,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-97,569,430.91	-116,305,968.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	244,576,828.00	285,483,448.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-61,827,623.78	-95,503,180.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119,297,697.13	112,744,054.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-52,954,011.19	-62,023,185.72
39216	Дуусаагүй барилга, байгууламж	7,400,000.00	7,400,000.00
39217	Ном	989,800.00	989,800.00
393	Биет бус хөрөнгө	98,168,000.00	89,428,000.04
39301	Програм хангамж	1,434,000.00	1,434,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-984,000.00	-1,134,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	101,029,840.00	97,718,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-3,311,840.00	-8,589,999.96
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,995,330,249.81	1,974,792,328.61
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,995,330,249.81	1,974,792,328.61
51	Засгийн газрын хувь оролцоо	1,995,330,249.81	1,974,792,328.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	783,673,589.00	783,673,589.00
51101	Өмч: - төрийн	783,673,589.00	783,673,589.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,035,068,475.91	1,014,530,554.71
51210	Өмнөх үеийн үр дүн	1,035,068,475.91	1,035,068,475.91
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-20,537,921.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	176,588,184.90	176,588,184.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,995,330,249.81	1,974,792,328.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	870,880,560.95	850,634,945.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	390,645,475.00	245,604,827.00
120	Нийтлэг татварын бус орлого	390,645,475.00	245,604,827.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	390,645,475.00	12,882,107.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,100,000.00	12,882,107.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	386,545,475.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	00.00	112,445,520.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	120,277,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	480,235,085.95	605,030,118.35
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,236,485.95	19,060,418.35
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,733,810.00	5,338,530.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,502,675.95	13,721,887.85
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	438,998,600.00	585,969,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	438,998,600.00	585,969,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	590,088,856.71	859,471,761.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	590,088,856.71	859,471,761.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	569,236,095.51	750,797,011.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,744,229.24	263,136,450.61
210101	Үндсэн цалин	255,071,029.24	249,798,150.61
210105	Гэрээт ажлын хөлс	5,673,200.00	13,338,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,265,232.00	33,969,487.19
210201	Тэтгэврийн даатгал	22,299,520.00	24,159,357.74
210202	Тэтгэмжийн даатгал	2,419,830.00	2,105,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,935,418.00	2,105,031.00
210204	Ажилгүйдлийн даатгал	434,264.00	507,102.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,176,200.00	5,092,696.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,939,976.00	46,877,257.61
210301	Гэрэл, цахилгаан	3,811,406.00	5,051,789.61
210302	Түлш, халаалт	43,108,570.00	41,585,468.00
210303	Цэвэр, бохир ус	20,000.00	240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,334,099.00	152,575,313.00
210401	Бичиг хэрэг	4,268,000.00	4,261,400.00
210402	Тээвэр, шатахуун	22,805,084.00	27,391,193.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	539,515.00	644,630.00
210404	Ном, хэвлэл	439,800.00	300,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	136,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	921,700.00	716,900.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	11,978,140.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	00.00	107,146,450.00
2105	Нормативт зардал	260,000.00	512,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	260,000.00	512,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,025,000.00	3,698,600.00
210604	Урсгал засвар	3,025,000.00	3,698,600.00
2107	Томилголт, зочны зардал	3,909,450.00	704,000.00
210702	Дотоод албан томилголт	1,840,000.00	704,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,069,450.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,504,392.60	25,274,138.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,578,224.60	20,724,293.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	606,740.00	534,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	380,520.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	155,428.00	71,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,253,716.67	224,049,765.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,936,090.00	64,595,428.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	780,000.00	2,301,007.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	128,537,626.67	157,153,330.43

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,852,761.20	108,674,749.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,600,000.00	6,045,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,600,000.00	6,045,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,252,761.20	102,629,749.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,144,873.85	97,176,984.59
213404	Хөрөнгийн	6,107,887.35	5,452,765.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	280,791,704.24	-8,836,816.43
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	264,458,944.00	11,701,104.77
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	11,701,104.77
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	264,458,944.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-264,458,944.00	-11,701,104.77
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	16,332,760.24	-20,537,921.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	484,335,085.95	610,785,025.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,100,000.00	5,754,907.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,100,000.00	5,754,907.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,100,000.00	5,754,907.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,100,000.00	5,754,907.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	480,235,085.95	605,030,118.35
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,236,485.95	19,060,418.35
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,733,810.00	5,338,530.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,502,675.95	13,721,887.85
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	438,998,600.00	585,969,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	438,998,600.00	585,969,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	471,325,285.95	610,334,025.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	471,325,285.95	610,334,025.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,472,524.75	500,914,275.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,637,382.15	263,136,450.61
210101	Үндсэн цалин	254,963,782.15	249,798,150.61
210105	Гэрээт ажлын хөлс	5,673,600.00	13,338,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,265,232.00	33,969,487.19
210201	Тэтгэврийн даатгал	22,299,520.00	24,159,357.74
210202	Тэтгэмжийн даатгал	2,419,830.00	2,105,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,935,418.00	2,105,031.00
210204	Ажилгүйдлийн даатгал	434,264.00	507,102.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,176,200.00	5,092,696.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,939,976.00	46,877,257.61
210301	Гэрэл, цахилгаан	3,811,406.00	5,051,789.61
210302	Түлш, халаалт	43,108,570.00	41,585,468.00
210303	Цэвэр, бохир ус	20,000.00	240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,135,799.00	34,476,854.00
210401	Бичиг хэрэг	5,042,000.00	4,856,200.00
210402	Тээвэр, шатахуун	22,804,984.00	27,392,124.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	539,515.00	644,630.00
210404	Ном, хэвлэл	439,800.00	400,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	136,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	949,500.00	1,047,100.00
2105	Нормативт зардал	260,000.00	512,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	260,000.00	512,000.00

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,832,000.00	7,604,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	50,000.00
210602	Тавилга	260,000.00	00.00
210604	Урсгал засвар	4,572,000.00	7,554,450.00
2107	Томилолт, зочны зардал	3,909,450.00	704,000.00
210702	Дотоод албан томилолт	1,840,000.00	704,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,069,450.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,419,505.60	27,446,317.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,493,337.60	22,896,472.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	606,740.00	534,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	250,520.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	155,428.00	201,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,073,180.00	86,187,459.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,095,680.00	83,886,452.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	977,500.00	2,301,007.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,852,761.20	109,419,749.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,600,000.00	6,790,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,600,000.00	6,790,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,252,761.20	102,629,749.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,144,873.85	97,176,984.59
213404	Хөрөнгийн	6,107,887.35	5,452,765.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,009,800.00	451,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,009,800.00	451,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,009,800.00	451,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,009,800.00	451,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,009,800.00	451,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-13,009,800.00	-451,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
S01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	771,855,589.00	95,527,357.09	150,008,585.03	1,017,391,531.12
S02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
S03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	771,855,589.00	95,527,357.09	150,008,585.03	1,017,391,531.12
S07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	734,911,537.01	734,911,537.01
S08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	783,673,589.00	176,588,184.90	1,035,068,475.91	1,995,330,249.81
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	783,673,589.00	176,588,184.90	1,035,068,475.91	1,995,330,249.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	783,673,589.00	176,588,184.90	1,035,068,475.91	1,995,330,249.81
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-20,537,921.20	-20,537,921.20
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	783,673,589.00	176,588,184.90	1,014,530,554.71	1,974,792,328.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/ төгрөгөөр /	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	588,969,700.00	494,547,622.41	94,422,077.59	84.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	588,969,700.00	494,547,622.41	94,422,077.59	84.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	582,179,700.00	487,757,622.41	94,422,077.59	83.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,152,800.00	263,136,450.61	16,349.39	100.0
210101	Үндсэн цалин	249,814,500.00	249,798,150.61	16,349.39	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	13,338,300.00	13,338,300.00	00.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,858,700.00	33,969,487.19	889,212.81	97.4
210201	Тэтгэврийн даатгал	24,332,500.00	24,159,357.74	173,142.26	99.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,105,300.00	2,105,300.00	00.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,631,600.00	2,105,031.00	526,569.00	80.0
210204	Ажилгүйдлийн даатгал	526,300.00	507,102.00	19,198.00	96.4
210205	Эрүүл мэндийн даатгал	5,263,000.00	5,092,696.45	170,303.55	96.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,991,500.00	46,877,257.61	114,242.39	99.8
210301	Гэрэл, пахилгаан	5,159,300.00	5,051,789.61	107,510.39	97.9
210302	Түлц, халаалт	41,592,200.00	41,585,468.00	6,732.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	240,000.00	240,000.00	00.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	35,444,600.00	34,476,854.00	967,746.00	97.3
210401	Бичиг хэрэг	4,893,400.00	4,856,200.00	37,200.00	99.2
210402	Тээвэр, шатахуун	28,234,300.00	27,392,124.00	842,176.00	97.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	706,100.00	644,630.00	61,470.00	91.3
210404	Ном, хэвлэл	400,800.00	400,800.00	00.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00	136,000.00	24,000.00	85.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,050,000.00	1,047,100.00	2,900.00	99.7
2105	Нормативт зардал	512,000.00	512,000.00	00.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	512,000.00	512,000.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,138,800.00	8,055,450.00	83,350.00	99.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	563,700.00	501,000.00	62,700.00	88.9
210604	Урсгал засвар	7,575,100.00	7,554,450.00	20,650.00	99.7
2107	Томилголт, зочны зардал	708,000.00	704,000.00	4,000.00	99.4
210702	Дотоод албан томилголт	708,000.00	704,000.00	4,000.00	99.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,877,300.00	13,838,664.00	38,636.00	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,300,000.00	9,288,819.00	11,181.00	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	535,000.00	534,025.00	975.00	99.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,000.00	250,520.00	26,480.00	90.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	201,300.00	201,300.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	178,496,000.00	86,187,459.00	92,308,541.00	48.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	175,896,000.00	83,886,452.00	92,009,548.00	47.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,600,000.00	2,301,007.00	298,993.00	88.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6790000.00	6790000.00	00.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,790,000.00	6,790,000.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,790,000.00	6,790,000.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	588,969,700.00	494,547,622.41	94,422,077.59	84.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	584,469,700.00	488,792,715.41	95,676,984.59	83.6
132001	Орон нутгийн төсвөөс	584,469,700.00	488,792,715.41	95,676,984.59	83.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,500,000.00	5,754,907.00	-1,254,907.00	127.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,500,000.00	5,754,907.00	-1,254,907.00	127.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	09.00	09.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	00.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00	00.00	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	09.00	09.00	00.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	05.00	05.00	00.00	100.0
650010	Гэрээт ажилтан	03.00	03.00	00.00	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	08.00	08.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41236485.95	19,060,418.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41236485.95	19,060,418.35
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35128598.60	13,607,653.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35128598.60	13,607,653.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35128598.60	13607653.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6107887.35	5452765.35
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6107887.35	5,452,765.35
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	6107887.35	5,452,765.35
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41236485.95	19060418.35
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41236485.95	19,060,418.35
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29733810.00	5,338,530.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11502675.95	13,721,887.35
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг дарга М.Зоригт, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ч.Батдорж нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, иргэнээ дээдэлсэн, өрх гэр, хүний хөгжлийг дэмжсэн төрийн захиргааны мэргэшсэн хамт олон байж ногоон эдийн засагт суурилсан манлайлагч сум болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 590,088.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,851.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,195.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 9,024.4 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,537.9 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82,657.7	118,077.7	35,420.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,000.0	8,127.2	7,127.2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	81,657.7	109,950.5	28,292.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,912,672.5	1,856,714.6	(55,957.9)
Үндсэн хөрөнгө	2,558,534.3	2,619,893.0	61,358.8
Хуримтлагдсан элэгдэл	(645,861.7)	(763,178.4)	(117,316.7)
Нийт хөрөнгө	1,995,330.2	1,974,792.3	(20,537.9)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,995,330.2	1,974,792.3	(20,537.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,995,330.2	1,974,792.3	(20,537.9)

Авлагын дансны үлдэгдэл 7,127.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх оны байгууллагаас авах 1,000.0 мянган төгрөгийн авлага барагдаагүй байгаа бол тайлант онд халаалтын шугам сүлжээг түрээслүүлсний төлбөрийн 7,127.2 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 109,950.5 мянган төгрөг болж 28,292.8 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал дансны үлдэгдэл 9,997.5 мянга, бичиг

хэргийн материал дансны үлдэгдэл 808.5 мянга, аж ахуйн материал дансны үлдэгдэл 16,739.8 мянга, бусад хангамжийн материал дансны үлдэгдэл 9,097.0 мянган төгрөгөөр тус тус өмнөх оноос нэмэгдсэн, мал амьтад дансанд бүртгэлтэй 8,350.0 мянган төгрөгийн хөрөнгийг байгууллагын даргын тушаалаар акталж данснаас хассан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,619,893.0 мянган төгрөг болж өмнөх оноос 61,358.8 мянган төгрөгөөр өссөн нь 451.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, 112,445.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 06 дугаар тогтоолоор 5,313.0 мянган төгрөгийн хөрөнгө сумын ЕБС-д шилжүүлж, 2021 оны 156 дугаар тогтоолын дагуу 46,224.7 мянган төгрөгийн хөрөнгө акталж, данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,974,792.3 мянган төгрөг болж 20,537.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 20,537.9 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд төсвийн нийт зарлагыг 576,731.5 мянга, санхүүжүүлэх эх үүсвэрийг 576,731.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 178,052.8 мянган төгрөгөөр бууруулж 398,678.7 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг тодотгон 588,969.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 585,969.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 5,754.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 494,547.6 мянган төгрөгийг зарцуулж 97,177.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 494,547.6 мянган төгрөг буюу 84.0 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 905.6 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 114.2 мянга, хангамж бараа материалын зардлыг 967.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 92,308.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын дуусаагүй үйлдвэрлэл дансанд 7,400.0 мянган төгрөгийн тоглоомын талбай бүртгэлтэй байгаа ба тус тоглоомын талбайн ажлыг гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлж ажлаа хугацаанд нь бүрэн хийгээгүй тул шүүхэд нэхэмжлэл гаргасны дагуу Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 131/ШШ2021/00679 тоот захирамжийн дагуу тус 7,400.0 мянган төгрөгийн гүйцэтгэгч иргэнээр төлүүлэхээр шийдвэр гарсан байна.

Тус шийдвэрийн дагуу 2021 онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 500.0 мянган төгрөг төлсөн ба үлдэгдэл 6,900.0 мянган төгрөгийн 2022 оны 03 дугаар сард төлөхөөр хүсэлт гаргасан байна.

Тайлант онд бусад хангамжийн материал дансанд аймгийн Сум дундын ойн ангиас 76,454.7 мянган төгрөгийн өвс тэжээл үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн ба 95,900.7 мянган төгрөгийн өвс тэжээлийг малчдад тарааж бараа материал шилжүүлсний зардлаар бүртгэсэн байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд нийт 50 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 92.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 859,471.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 269,382.9 мянган төгрөгөөр буюу 45.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, дотоод албан томилолтын зардал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 788,877.2 мянган төгрөгийн 151 мэдээлэл мэдээлэхээс 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, орлого зарлагын гүйлгээтэй холбоотой 243,807.1 мянган төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 398,678.6 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 190,291.1 мянган төгрөг нэмж 584,469.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 4,500.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 494,547.6 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 16.0 хувийн хэмнэлт гаргасан. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад урсгал зардлын төсвийг 109,755.5 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 181,202.7 мянган төгрөг нэмж 290,958.2 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 197,441.7 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 32.1 хувийн хэмнэлт гаргасан.

- Бичиг хэргийн зардлыг 4,893.4 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 4,856.2 мянган төгрөг зарцуулсан байна.

-Албан томилолтын зардлыг 708.0 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 704.0 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан төсөвт 0.6 хувийн хэмнэлт гаргасан.

- Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 48,837.2 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 1,545.7 мянган төгрөг хасаж 47,291.5 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 46877.3 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 1,959.9 мянган төгрөг буюу 4.0 хувь хэмнэсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 63,901.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 46,212.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 17,689.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,560.7 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс 1,000.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 3,127.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,433.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгч, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй мэдээллийг нөхөн мэдээлэх, Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах 2 зөвлөмж өглөө.

4.1 Төлбөрийн акт

1. Тус байгууллагын уурын зуухыг түрээслэгч Залаа цагаан хоршоо ХХК нь 7,127.2 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг төлөөгүй авлагаар бүртгэсэн ба 2022 оны 02 сард 4,000.0 мянган төгрөгийг төлсөн ба 3,127.2 мянган төгрөгийг төлөөгүй байна..

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил,

гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээслэгч Залаа цагаан хоршоогоор 3,127.2 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

4.2 Албан шаардлага

1. Баянхонгор аймгийн Статистикийн хэлтсээс нэмэлт дансаар хүлээн авсан хагас жилийн мал тооллогын 12 тоологчийн 433.5 мянган төгрөгийн цалинг Нийгмийн даатгалын хэлтэст мэдээлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст дутуу мэдээлсэн ажилчдын 2021 оны 433.5 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Авлагын дансанд үлдэгдэлтэй байгаа 1000.0 мянган төгрөгийн авлага нь 2016 онд үүссэн олон жилийн насжилттай байгууллагаас авах авлага байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онуудад үүссэн олон жилийн насжилттай 1,000.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх албан шаардлага өгөх.

4.2 Зөвлөмж

1. Тайлант хугацаанд оруулбал зохих 788,877.2 мянган төгрөгийн 151 мэдээлэл мэдээлэхээс 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, орлого зарлагын гүйлгээтэй холбоотой 243807.1 мянган төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.,

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг 7 хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 48,837.2 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 1,545.7 мянган төгрөг хасаж 47,291.5 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 46877.3 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 1,959.9 мянган төгрөг буюу 4.0 хувь хэмнэлт гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 дахь “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар	6	5560.7	1	1000.0	1	3127.2	2	1433.5	2	-

_____оОо_____